БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 21 өдөр Дугаар А/127 Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 131 дүгээр тогтоол, Засаг даргын зөвлөлийн 2014 оны 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн "Агаарын бохирдлыг бууруулах" нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд хосолмол бүсийн айл өрхийг эрчим хүчний хэмнэлттэй, бүрэн шаталттай сайжруулсан зуухаар хангаж дуусгах ажлыг эрчимжүүлэх зорилгоор хосолмол бүсэд хамрагдсан хороодын дунд 2014 оны 02 дугаар сарын 17-ноос 2014 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд болзолт уралдаан зарласугай.

2. Уралдааныг зохион байгуулж, дүгнэн шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, болзлыг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Уралдааны шагналд шаардагдах 2,185,000/хоёр сая нэг зуун наян таван мянган,/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Тамгын газрын нягтлан бодогч /Б.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү уралдааны явц, биелэлтэнд хяналт тавьж эрчимтэй зохион байгуулах, бодит ажил болгон хэрэгжүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Г.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ОРОСОО

1160200378

Баянгол дүүргийн Засаг даргын
2014 оны 02 дугаар сарын 21 -ны өдрийн
А/127 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ГЭР ХОРООЛЛЫН ХОРООДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛЗОЛТ УРАЛДААНЫГ ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Г.ЭНХБОЛД	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	М.ГАЛБАДРАХ	Агаарын бохирдол хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Т.НЯМЦЭЦЭГ	Засаг даргын Тамгын газрын дарга
	Э.БАТБИЛЭГ	Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга
	Б.БАТБАЯР	Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн мэргэжилтэн
	О.НОМИН-ЭРДЭНЭ	Агаарын чанарын мэргэжилтэн
	Ж.БОЛОРЧИМЭГ	Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дэргэдэх тасгийн нягтлан бодогч

Баянгол дүүргийн Засаг даргын
2014 оны 02. дугаар сарын 21. -ны өдрийн
А/127 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН "АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ" НЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХОСОЛМОЛ БҮСЭД БАГТСАН ХОРООДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

1. *Уралдааны зорилго:*

Монгол Улсын Засгийн газар, Улаанбаатар Цэвэр агаар төслөөс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй эрчим хүчний хэмнэлттэй, бүрэн шаталттай, сайжруулсан зууханд хосолмол бүсийн айл өрхийг бүрэн хамруулж дуусгах, иргэдэд сурталчилах, түгээх, борлуулахад уралдааны зорилго оршино.

2. *Хугацаа:*

Болзолт уралдаан 2014.02.17-ноос 2014.04.15-ний өдөр хүртэлх хугацаанд явагдана.

3. *Хамрагдах хүрээ:*

Агаарын чанарыг сайжруулах хосолмол бүсэд багтсан Баянгол дүүргийн гэр хорооллын 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23 дугаар хороод хамрагдана.

4. *Шалгуур үзүүлэлт:*

- Хязгаарлалтын үндсэн бүсэд багтсан хороо байх;
- Үндсэн оршин суугч нараа бүрэн шаталттай сайжруулсан зууханд бүрэн хамруулж дуусгах.
- Боловсруулсан түлшний борлуулалтыг нэмэгдүүлсэн.
- Зээлээр сайжруулсан зуух авсан иргэдийн зуухны төлбөрийг бүрэн барагдуулсан.
- Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний эсрэг гарсан зөрчил, дутагдлыг илрүүлсэн байдал.
- Нутаг дэвсгэртээ түүхий нүүрс түлж, зарж борлуулахгүй байх, тэдгээрт арга хэмжээ авсан байдал.
- Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд шинээр санаачлан зохион байгуулсан ажил.

5. *Уралдааныг дүгнэх, шагнал урамшуулал:*

Уралдаан 2014.02.17-наас 2014.04.15-ний өдөр хүртэл хугацаанд явагдах бөгөөд уралдааныг шалгаруулах ажлын хэсэгт 2014 оны 04 дүгээр сарын 15-ны дотор хороод тайлан мэдээг Дэд бүтэц, тохижилтын хэлтэст ирүүлнэ.

Уралдааныг дүгнэх ажлын хэсэг нь ирүүлсэн материалыг үндэслэн хийгдсэн ажлыг баталгаажуулж шалгаруулалтыг явуулна.

6. *Шагналын сан:* 2.100.000 төгрөг.

Нэгдүгээр байр 1	- өргөмжлөл, 1.000.000 төгрөг
Хоёрдугаар байр 1	- өргөмжлөл, 700.000 төгрөг
Гуравдугаар байр 1	- өргөмжлөл, 400.000 төгрөг

Баянгол дүүргийн Засаг даргын
2014 оны .02. дугаар сарын 21. -ны өдрийн
А/127 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН "АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ" НЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХОСОЛМОЛ БҮСЭД БАГТСАН ХОРООДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ УРАЛДААНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ.

Д/д	Бараа бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Нийт дүн
1	Эх бэлтгэл	ш	1	10,000	10,000
2	Хэвлэл	ш	3	10,000	30,000
3	Жааз	ш	3	15,000	45,000
4	Шагналын сан			2,100,000	2,100,000
Дүн					2,185,000